**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

---

# Чандмань сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ГАА-2023/13/-НА-СТА-ТТЗ**


Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 138

танай ______ -ны № ______ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ч.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2/5-д заасны дагуу Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн байна.

Сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд 7 хөтөлбөрийн 144 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 91 хувьтай биелүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

0702000330

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

| | Үзүүлэлт | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| **Санхүүгийн байдлын тайлан** | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 716.5 | 633.3 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 5,138.7 | 951.2 |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **5,855.1** | **1,584.5** |
| | Нийт өр төлбөрийн дүн | 12.5 | - |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 5,842.6 | 1,584.5 |
| | **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **5,855.1** | **1,584.5** |
| **Үр дүнгийн тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 3,505.1 | 1,099.0 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 3,292.8 | 839.6 |
| | **Үйл ажиллагааны үр дүн** | **212.3** | **259.4** |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | 153.5 | 4,522.1 |
| | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **58.7** | **-956,310.5** |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | 97,363.4 | -4,262.7 |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,842.6 | 5,847.2 |
| | Тайлант оны үр дүн | 4.6 | -4,262.7 |
| | **Эцсийн үлдэгдэл** | **5,847.2** | **1,584.5** |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 2,965.6 | 1,016.6 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 2,809.2 | 664.1 |
| | **Үйл ажиллагааны ЦМГ** | 156.4 | 352.5 |
| | **Хөрөнгө оруулалтын ЦМГ** | -71.2 | -208.6 |
| | **Санхүүгийн ажиллагааны ЦМГ** | 0.0 | -191.0 |
| | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **85.2** | **-47.2** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 178.0 | 263.3 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 263.3 | 216.1 |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | | |
| | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **2,109.1** | **1,022.9** |
| | Урсгал зардал | 2,046.8 | 651.5 |
| | Хөрөнгийн зардал | 62.3 | 180.4 |
| | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **2,191.9** | **924.7** |
| | Улсын төсвөөс санхүүжих | **1,459.5** | - |
| | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 643.8 | 896.8 |
| | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 8.6 | - |
| | **Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас** | 80.0 | 27.9 |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 148.4 | 230.7 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 231.1 | 132.5 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 25.9 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 25.9 сая төгрөгийн 2 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

**3.1 Албан шаардлага**

- ✓ Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 2.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 0.2 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 1.3 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварын орлого 11.4 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.
- ✓ Батлагдсан төсвөөс төсөвт байгууллагуудад санхүүжилтийг олгохдоо 10.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 5 | 60.9 | - | - | 5 | 60.9 | 5 | 60.9 | - | - | - | - |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 2 | 1.5 | - | - | 2 | 1.5 | 2 | 1.5 | - | - | - | - |
| Хоршоо хөгжүүлэх сан | 3 | 177.2 | - | - | 3 | 177.2 | 3 | 177.2 | - | - | - | - |
| ОНХС | 4 | 206.6 | - | - | 4 | 206.6 | 4 | 206.6 | - | - | - | - |
| **Дүн** | **14** | **446.2** | **-** | **-** | **14** | **446.2** | **14** | **446.2** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Чандмань сумын ТТЗ | 2 | 25.9 | - | - | 2 | 25.9 | - | - | - | - | - | - |
| ЗДТГ | 10 | 74.3 | 3 | 11.8 | 7 | 62.5 | - | - | 1 | 1 | - | - |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 0.2 | 1 | 0.2 | - | - | - | - | - | - | - | - |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 3 | 1.7 | 2 | 1.6 | 1 | 0.08 | - | - | - | - | - | - |
| ОНХС | 2 | 55.0 | - | - | 2 | 55.0 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **18** | **157.1** | **6** | **13.6** | **12** | **143.5** | **-** | **-** | **1** | **1** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| ИТХ | 1 | 1.1 | - | - | 1 | 1.1 | - | |
| Дүн | 2 | 1.1 | - | - | 1 | 1.1 | 1 | - |
| **Нийт дүн** | **2** | **1.1** | **-** | **-** | **1** | **1.1** | **1** | **-** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТТЗ | 1 | 1 | - | | 1 | - | - | - |
| 2 | ЗДТГ | 1 | 1 | | | | 1 | | |
| 3 | ИТХ | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | ОНХС | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | **5** | **2** | **3** | | **1** | **1** | | |

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР